

Монгол хувцасны уламжлалт ур хийцийн системчлэл ба мэдээллийн сан бүрдүүлэх асуудалд

Чулууны Алтанцэцэг 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ chuluunalt@gmail.com

Паламханы Болормаа 

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дизайны тэнхим,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Монгол үндэсний хувцас нь угсаатны соёл, ахуй, гоо зүй, оюуны бүтээлч байдлыг илэрхийлсэн өвөрмөц соёлын өв юм. Энэхүү өгүүлэлд уламжлалт хувцасны хийц, урлалын онцлогийг системтэйгээр судалж, дижитал мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйг танилцуулсан. Судалгаанд морфологи бүтцийн шинжилгээ, график зураглал, эсгүүрийн дэлгэмэл зураг, техникийн зураглалын баримтжуулалт, чимэглэлийн элементүүдэд хийсэн дүн шинжилгээ, үйл урлалын технологи зэрэг олон талт шинжилгээний аргыг ашигласан болно. Судалгааны үр дүнд үндэсний хувцасны бүрдэл хэсгүүдийг тодорхойлон ангилж, кодчиллын зарчимд үндэслэн технологийн картын загварыг боловсруулсан.

Цаашид судалгааны энэхүү арга зүйг үндэстэн, угсаатны бүлэг тус бүрийн хувцасны мэдээлэлд ашигласнаар орчин үеийн программ хангамж болон дижитал технологийг өргөн ашиглах, дижитал архив үүсгэх зэргээр соёлын өвийг хамгаалан хадгалах, хэрэглээнд шингээх өргөн боломж бүрдэж байгааг энэ судалгаанд харуулсан. Энэхүү судалгаа нь орчин үеийн дизайнер, урлаачдад уламжлалт соёлыг шинэ өнцгөөр сэргээн хэрэглэх, өв соёлыг хамгаалах, архивлахад чиглэсэн чухал мэдээлэл, эх сурвалжийг нэгтгэх зэрэг мэдээллийн сан бүрдүүлэх ажилд ихээхэн ач холбогдолтой.

Түлхүүр үгс: уламжлалт урлал, хувцасны хийц технологи, технологийн карт, дижитал кодчлол

Systematization of traditional Mongolian costume design and the creation of a digital information system

Altantsetseg Chuluun 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
[✉chuluunalt@gmail.com](mailto:chuluunalt@gmail.com)

Bolormaa Palamkhan 

Department of Design, School of Industrial Technology, Mongolian University
of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The Mongolian national costume represents a unique form of intangible cultural heritage that embodies ethnic identity, traditional lifestyle, aesthetics, and intellectual creativity. This study presents a systematic analysis of the structural and artisanal characteristics of traditional garments and proposes a methodology for developing a digital information archive. The research employs a multidisciplinary approach, including morphological structure analysis, graphic schematics, pattern layout documentation, technical illustrations, decorative element analysis, and traditional crafting technologies. As a result, the study categorizes key structural components of national costumes and develops a model for codified technical cards based on standard classification principles.

The proposed methodology demonstrates significant potential for application across various ethnic groups' traditional costumes. It emphasizes the importance of utilizing modern software and digital technologies to preserve, document, and integrate cultural heritage into contemporary use through the development of digital archives. Furthermore, this research provides valuable resources and inspiration for modern designers and artisans seeking to reinterpret traditional culture and safeguard it through structured documentation and digital preservation efforts.

Keywords: *traditional craftsmanship, clothing structure and technology, technology card, digital coding*

Оршил

Монголчуудын хувцасны соёл нь тэдний оюуны хөгжлийн өсөлт, урлах арга ухаан, аж төрөх ёс, гоо зүйн таашаал, зан заншил зэргийг тусган харуулж, үеэс үед уламжлагдан хөгжиж боловсорсоор ирсэн баялаг уламжлалтай бөгөөд монголын болон гадаадын олон орны эрдэмтэд сонирхон судалсан байдаг.

Хувцсанд тухайн ард түмний соёлын тэмдэг, элементүүд хадгалагдаж байдаг. Дэлхий дахинд даяаршлын өнөөгийн давалгаанд нийгмийн хөгжил хурдацтай явагдаж, соёлын өөрчлөлт, ялангуяа үндэсний хувцасны соёлд асар их нөлөө үзүүлж, өөрчлөгдөх, уусах, устах аюулд өртөж байна. Мөн эртний уламжлалт хувцас нь байгалийн гаралтай ноос, торго, хөвөн зэрэг нэхмэл болон арьс ширэн материалаар хийсэн байдаг тул он удаан жил хадгалах боломжгүй, хурдан

өгөрч мууддаг шинж чанартай. Музей, галерей, хувийн цуглуулагч нар хувцас хэрэглэлийг шаардлага хангасан орчинд хадгалдаг хэдий ч тодорхой хугацааны дараа устаж үгүй болох аюул нүүрлэж байна. Ийм нөхцөлд ялангуяа орон нутгийн музейд байгаа хувцас эдлэлийг яаралтай судалж, бусад орны жишгээр дижитал технологи ашиглаж мэдээллийг нь хадгалж үлдэх нь чухал байна.

Уламжлалт үндэсний хувцасны дижитал мэдээлэл цуглуулгын арга, төрлүүдэд хоёр хэмжээст дүрс, гурван хэмжээст скайнер, микро скайнер, динамик видео болон бусад дижитал технологийг хэрэглэж байна. Дижитал технологи нь үндэсний хувцасны соёлыг хамгаалахад илүү тогтвортой хэрэгсэл, мэдээллээр хангах шийдэл, боломжийг олгож байна.

Энэхүү өгүүлэлд монгол үндэсний хувцсыг судлахдаа хувцсанд агуулагдаж байгаа угсаатны баримт, мэдээлэл болон урлал, зохион бүтээлтийн шинжилгээг хийж хийцийн болон үйл урлалын цогц мэдээллийг цуглуулах, кодлох, улмаар сан бүрдүүлэх боломжийн талаар бичсэн бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/759 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл”-ийн жагсаалтын 7-р айд багтсан “Халх хувцасны уламжлалт урлал” өвд багтах халх эхнэр дээлийн хийц загварын жишээн дээр үзүүлэв.

Судалгааны арга зүй

Судалгааны объект: Үндэсний хувцас, халх эхнэр дээл

Судалгааны арга: Үндэсний хувцасны уламжлалт урлал, хийц технологийн судалгааны үндэс нь хувцасны олон талт мэдээллийг багтаасан морфологи бүтцийн системчилсэн хандлага юм (Bertoluci, Sanches 2020, 108-137). Энэ нь Bertoluci & Sanches (2020) нарын “morphological chart”-д суурилсан загварын бүтээгдэхүүн боловсруулах арга зүй бөгөөд судалгааг хийхдээ дараах зурагт үзүүлсэн системийн мэдээллийг бүрдүүлэв (Зураг 1).



Зураг 1. Үндэсний хувцасны мэдээлэл бүрдүүлэх систем

Судалгааны үр дүн

Монгол үндэсний хувцасны загвар хийц, урлалын түүхэн талаарх судалгааг Х.Нямбуу (1992), Ч.Авдай, С.Төмөржав (2003), Ж.Саруулбуян, Л.Энхтуяа (2011, 2012) нарын бүтээлүүдэд тусгасан байдаг. Үүнээс гадна Б.Дунгаамаа (2022), Л.Ишдорж (2011), Т.Өлзийгэрэл (2008) нар хувцасны зохион бүтээлт, хийцийн элементүүдэд үндэслэн орчин үеийн загварчлалын аргыг судалсан нь суурь материал болов. Харин дижитал кодчлол, системчлэл, технологийн картын бүрдүүлэлтийн талаар гадаадын судлаач Bertoluci & Sanches (2020) нар морфологийн шинжилгээнд суурилсан загварын хөгжүүлэлтийн арга зүйг танилцуулсан нь энэ судалгааны онолын үндэслэлд чухал нөлөө үзүүлэв. Монгол Улсад MNS ISO 15535:2019¹, MNS ISO 20685-1:2019² зэрэг стандартуудыг үндэсний хэмжээний мэдээллийн сан үүсгэхэд ашиглаж байгаа нь дижитал хадгалалтын арга зүйд шинэ боломжуудыг нээж байна.

Үндэсний хувцасны уламжлалт урлал, хийц технологийн судалгаанд график зураглал, харьцаанд дүн шинжилгээг хийх эмперик, чанарын судалгааны арга зүйг ашиглан загварчлал болон системчлэн боловсруулах аргаар үр дүнг нэгтгэн (Алтанцэцэг 2015) боловсруулав. Тухайлбал, хувцасны морфологи бүтцийн системчлэлд:

1. Хийцийн шинжилгээ
 - 1.1. Зориулалт, ангилал
 - 1.2. Техникийн зураг
 - 1.3. Эсгүүрийн үлгэрийн зураглал, дэлгэлт
 - 1.4. Хувцасны хэлбэр, силуэт
 - 1.5. Бүрдэл хэсгүүдийн харьцаа зохицол
 - 1.6. Өнгө
 - 1.7. Чимэглэлийн элемент
2. Үйл урлалын шинжилгээ
 - 2.1. Оёдлын зангилаа хэсгийн модуль зүсэлт
 - 2.2. Үйл урлалын арга, технологи (эсгэх, оёх, наах, зангидах г.м) нэршил, арга, технологи
 - 2.3. Бөс даавуу, бусад материал

Дээрх ангиллын дагуу үндэсний хувцсыг судлахдаа:

- хувцасны бүтэц, загвар, бүрдэл хэсгүүдийн уран сайхан-зохион бүтээлтийн шинжилгээг хавтгайн болон гурван хэмжээсээр хийх;
- даавуу материалын төрөл бүтэц, хээ чимэглэл, өнгөний харьцаа, зохицлыг тодорхойлох;
- эсгэх, оёх, чимэглэх арга технологийн нарийвчилсан судалгааг хийж технологийн картын сан үүсгэх нь чухал юм.

Энд жишээ болгож Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/759 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын Соёлын биет бус өвийн

¹ Антропометрийн хэмжээний өгөгдлийн сан үүсгэх ерөнхий шаардлага. Стандарт хэмжил зүйн газар.


² Олон улсын хэмжээний антропометрийн гурван хэмжээст хэмжилтийн өгөгдлийн сан үүсгэх арга зүй. Стандарт хэмжил зүйн газар.

төлөөллийн үндэсний бүртгэл”-ийн жагсаалтын 7-р айд багтсан “Халх хувцасны уламжлалт урлал” өвд багтах зарим судалгааг танилцуулав.

Халх эхнэр дээлийн урлал - зохион бүтээлтийн шинжилгээ



Зураг 2. Халх эхнэрийн гоёлын дээл³




а-ё


Зураг 3. Халх эхнэрийн гоёлын дээлийн хэлбэр, бүрдэл хэсгийн харьцаа⁴

- ³а. Халх эхнэр дээл (Ядамсүрэн 1967. БНМАУ-ын Ардын хувцас)
б. Богдын шар ордны өмнөх шөргөн хашааны дэргэд зогсож буй халх эхнэр, Нийслэл хүрээ. Гэрэл зургийг Стефан Пассе, 1913 оны VII сар (Улаанбаатар хотын музей)
в. Халх эхнэр (Саруулбуян, Энхтуяа 2011, 74)
г. Хүрээний монгол авхай нар, 1910-аад он (Улаанбаатар хотын музей)
д. Лам, эхнэр, хүүхэд 1920-оод оны эхэн (Саруулбуян, Энхтуяа 2012, 17)
е. Монгол бүсгүйчүүд, Нийслэл хүрээ. Гэрэл зургийг Roy Chapman Andrews, 1919.
⁴ а. Эхнэр дээл, XX зууны эх. Торго, даавуу. 122*98*103.5 см. УБМ60.5 (Цэндсүрэн (ред.) 2014, 125)
б. Эхнэр дээл, Завхан аймгийн музейн үзмэр. (Цэндсүрэн (ред.) 2014, 75)
в. Халх эхнэр дээл, XIX-XX зуун. Торго, даавуу, эсгий, гууль. 126.5*51 см. 60-2 (Цэндсүрэн (ред.) 2014, 395)
г. Эхнэр дээл, XX зуун. Торго, даавуу. 115*25 см. 70.84 (Цэндсүрэн (ред.) 2014, 20)
д. Халх эхнэрийн дээл. Монголын үндэсний түүхийн музейн үзмэр (Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн 2004, 165)
е. Халх эхнэр дээл, 119*50*107 см. Y.88x-4-4. Монголчуудын хувцас (Саруулбуян, Энхтуяа 2012, 73)
ё. Халх эхнэр дээл. XIX-XX зуун. Торго, хоргой, өнгийн тууз. 120*50 см (Монголын Үндэсний музейн үзмэр)

Халх угсаатны эхнэр дээлийн (Зураг 2, 5) хэлбэрийн судалгааг хийхдээ харьцуулалтын аргыг ашиглан ижил төстэй хувцаснуудыг бүлэглэн (Зураг 3), загварын дизайн, өнгийн хоршил, хэлбэр, элементийн зохиомж, бүрдэл хэсгийн харьцаа, даавуу материал, хээ угалз зэргийг харьцуулан гоёлын болон өдөр тутмын гэж ангилсан ба бүрдэл хэсгийг давхцуулан дээлийн ерөнхий хэлбэр, дундаж харьцаа, хуваалт, чимэглэлийн элемент, бүрдэл хэсгүүдийг (Зураг 4, 6) тодорхойлсон болно.



Зураг 4. Гоёлын дээлийн гадаад байдал, эсгүүрийн үлгэрийн дэлгэлт



Зураг 5. Халх эмэгтэй өдөр тутмын дээлийн хэлбэр, бүрдэл хэсгийн харьцаа⁵


Даавуу материал сонгох, өнгө хослуулах, оёх, наах, цардах нь урлаачийн онцлог, уран чадвар, хувь хүний сэтгэлгээ зэргээс шалтгаалан олон янз байна. Үйл урлалын дүн шинжилгээг хийхдээ үүнийг анхаарч голч байдлыг баримтлах нь зүйтэй.

⁵а. Монголын эмэгтэйчүүд, XIX зуун (Чулуун С. (ред.) 2014, 222)

б. Төв халх эмэгтэйчүүд (Чулуун С. (ред.) 2014, 41)

в. Монгол эмэгтэйн дээл, ууж (Чулуун С. (ред.) 2014, 222)


г. Эхнэр дээл, 1910-1970 он. Чисчүү, торго. 124*54 см. 65-4-19. Баянхонгор аймгийн музейн үзмэр (Цэндсүрэн (ред.) 2014, 235)



Зураг 6. Халх эхнэрийн өдөр тутмын дээлийн гадаад байдал, эсгүүрийн үлгэрийн дэлгэлт

Технологийн карт, мэдээллийн сан үүсгэх

Хийц, үйл урлалын нарийвчилсан судалгаа шинжилгээг хийж мэдээллийн сан үүсгэх бөгөөд олон улсын мэдээллийн сан бүрдүүлэх MNS ISO 15535:2019, MNS ISO 20685-1:2019 стандартыг ашиглан олон улсын мэдээллийн сан бүрдүүлэх үндсэн шаардлагын дагуу бүртгэлжүүлж кодчилно (Зураг 7).



Зураг 7. Хувцасны мэдээллийн кодчлол

Хийц, үйл урлалын нарийвчилсан судалгаа шинжилгээг хийхдээ ангилах шалгууруудыг боловсруулах, бүлэг хэсгүүдэд ангилах, хувилбар бүрийг дараалалд оруулах (Зураг 8) зэрэг нарийвчилсан үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Уламжлалт хувцасны загварыг кодчилох, дижитал хэлбэрт оруулах чиглэлээр хийгдсэн судалгааны ажлууд хийгдэж эхлээд байгаа бөгөөд уламжлалт соёлын элементүүдийг орчин үеийн загварт хэрхэн шингээх, дижитал хэрэгслээр хэрхэн хадгалах, сэргээх талаар илүү хөгжиж байна.

Уламжлалт хувцасны хийц, технологитой мэдээллийг дижитал хэлбэрээр хадгалах, систем бүрдүүлэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:



1. Үндэсний уламжлалт хувцасны хийц загвар, зохиомжийн шийдэл, уран сайхны илэрхийллийг тухайн угсаатны ахуй, өв соёлын уламжлал, үндэсний сэтгэлгээтэй уялдуулан судлах эх сурвалж болно.
2. Үндэсний хувцас, түүнийг урлах торго даавуу болон бусад хэрэглэлийг бүтээх ур ухаан, арга технологи, багаж хэрэглэлийн талаар судалж мэдэх, уламжлуулан хадгалахад эх сурвалж болно.
3. Орчин үеийн хувцас загвар зохион бүтээгчдэд уламжлалт соёл, хувцасны дизайны илүү баялаг материал, мэдээлэл өгч, үндэсний хувцасны гайхамшигт өвөөс сэдэл санаа авах, онгодоо хөглөх, урам зоригийн өдөөлт авдаг. Энэ нь уламжлалт соёлыг орчин үеийн соёлд улам бүр шингээж, өвлөн үлдээх боломжтой болгодог. Ялангуяа, шинэ дизайн бүтээх дижитал хэрэгслийг илүү сайн мэддэг, ашиглах чадвартай залуу дизайнеруудад хувцасны соёлын өвийг тогтвортой, хэрэглээний бүтээгдэхүүн болгоход дэм болно.

Үндсэн бүрдэл хэсэг			Бүрдэл хэсгийн задаргаа	Эх бие		Эмжээр, мөшгөөр							Бусад			
				Үндсэнэд		Эд				Оёх арга			Дүүргэгч			
				Торго , даалимба	Өөр өнгийн торго	Хурга, булга, халиу [6]	Хоргой [3]	Саатай торго [6]	Хилэн [2]	Эрээн тууз [3]	Тасам [5]	Нарийн эмжээр [5]	Дан [5]	Давхар [5]	хошмог [6]	Цардсан эсгий [3]
F	Энгэр	1	Энгэр													
		2	Цөлц энгэр [1]													
		3	Хүн энгэр [1]													
		4	Цэгзэр (жижиг) энгэр [3]													
		5	Сүм энгэр [1]													
		6	Урд хормой													
		7	Урд хормойн эмжээр													
		8	Дэнхэв (дэнхув) [1] татаас [4]													
		9	Дотоод энгэр [1]													
		10	Оноо [1]													
B	Ар	1	Ар [1]													
		2	Ар хормойн эмжээр [1]													
S	Ханцуй	1	Эрүү [1] (эрүүвч [2]) ханцуй													
		2	Болино ханцуй [6]													
		3	Эрүү [1] ханцуйны дотор тал													
		4	Мөшгөөр [1], мөшгөөрийн даруулга [6]													
		5	Түрүү [1]													
SS	Түнтэр мөр	1	Ходоодон түнтэр мөр [1], [6]													
		2	Дугуй түнтэр [1], [6]													
C	Зах	1	Зах													
		2	Захны эмжээр													
SF	Нударга	1	Нударга гадар													
		2	Нударга дотор													
		3	Нударгын эмжээр													

Зураг 8. Халх эхнэр дээлийн хийц, үйл урлалын шинжилгээний нэгтгэл

Мэдээллийн сангийн кодчиллыг хийхдээ үндсэн мэдээллийн дарааллын дагуу цувруулан үсэг (латин үсэг ашиглах нь илүү тохиромжтой), тоо хосолсон байдлаар бичнэ (Зураг 7, 8).

Кодчилж буй загвар тус бүр дээр технологийн картын файл үүсгэн архивлана (Зураг 9). Технологийн картад тухайн хувцастай холбоотой бүх төрлийн мэдээлэл багтах бөгөөд кодын дотор агуулагдаж буй мэдээллүүдийн нэгтгэл байна.

Хувцасны нэр, дугаар	Угсаатны бүлэг	Улирал	Хүйс	Өмсөх зориулалт, төрөл
D 01	01	SM	Эрэгтэй	Өдөр тутам С
Халх эхнэр дээл	халх	SP	Эмэгтэй W	Хүндэтгэл Н
Урлал, зохион бүтээлтийн шинжилгээ				
Хийцийн шинжилгээ		Үйл урлалын шинжилгээ		
Хувцасны гадаад байдлын зураг	Хийц, загварын тодорхойлолт	Бүрдэл хэсгийн онцлог, ялгаатай байдал		
		01	Хэлбэр, силуэт	A хэлбэр -04
		001	Өнгө	001, 003
		001	Чимэглэлийн элементүүд	D01.01-SMWC01.01.001.002
	Эсгүүрийн хэмжээ	F	Энгэр	Цөгц энгэр [1], Хүн энгэр [1]- F02, F03
		B	Ар	Ар [1] – B01, B02
		S	Ханцуй	Эрүү [1] (эрүүвч [2]) ханцуй – S01, S02
		C	Зах	Захны эмжээр – C01, C02
Оёдлын онцлог/ зүсэлтийн схем	Хэлбэр, силуэтийн харьцаа	SF	Нударга	Нударгын эмжээр- SF03
			Бөс, даавуу материал	
		SM	Үндсэн/ гадар	Ноос – SM1
		IM	Дотор	Үстэй – IM3
		DM	Чимэглэл	Хоргой – DM2
		BM	Товч	Ясан товч- BM4
				D01.01-SMWC(F01.B2.S01.C01.SF03. SM1).002.001

Зураг 9. Технологийн карт: Халх эхнэр дээл, код

Хэлэлцүүлэг

Сүүлийн жилүүдэд үндэсний хувцасны өв соёлыг дижитал хэлбэрээр хадгалах, системчлэн архивлах, орчин үеийн хэрэглээнд шингээх чиглэлээр олон улсад болон Монгол Улсад тодорхой судалгаанууд хийгдэж эхэлсэн. Энэхүү судалгаанд үндэсний уламжлалт хувцасны хийц загвар, технологийг шинжлэх ухаанч аргаар ангилж, морфологи шинжилгээ, техник загварчлал, технологийн үйл явцын кодчлол зэрэг элементийг нарийвчлан тусгасан нь ач холбогдол бүхий шинэ алхам боллоо.

1. Монгол үндэсний хувцасны бүтэц, чимэглэл, материалын онцлог, хэлбэрийн хувьсал нь зөвхөн гоо зүйн утга агуулга бус угсаатны бүлгийн ахуй амьдрал, сэтгэлгээний тусгал байдаг. Иймд уг хувцасны хийц, урлалын мэдээллийг нарийвчлан судалж, дижитал хэлбэрт буулган архивлах нь соёлын өвийг хадгалах үндэсний хэмжээний стратегийн зорилт юм.
2. Мөн уламжлалт хувцасны дижитал кодчлол, технологийн картын систем нь зөвхөн музей, эрдэм шинжилгээний байгууллагад бус, орчин үеийн загварын дизайнерууд, үйлдвэрлэл эрхлэгчдэд үнэтэй мэдээллийн эх сурвалж болж байна. Энэ нь соёлын өвийг бүтээлч үйлдвэрлэлтэй холбох, үндэсний хувцасны элементүүдийг орчин үеийн загварт шингээж, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжийг нээж өгч буй хэрэг юм.
3. Залуу судлаач, дизайнерууд дижитал технологид суурилсан платформуудыг үр ашигтай ашиглах, уламжлалт хийц технологийн өгөгдөлд тулгуурлан шинэ загвар зохион бүтээх боломж бүрдэж байна. Үүний зэрэгцээ үндэсний хувцасны ховор эд өлгийн дурсгалыг сэргээн засварлах, мэдээлэлжүүлэх, олон улсын мэдээллийн системд бүртгэх шаардлага улам нэмэгдэж байгааг анхаарах хэрэгтэй.

4. Энэхүү судалгаа нь зөвхөн нэг хувцасны төрөлд (эхнэр дээл) төвлөрсөн боловч бусад угсаатны бүлгийн хувцасны судалгаанд өргөтгөж болох арга зүйн суурийг тавьж буй нь онцлогтой. Цаашид системчилсэн, олон улсын жишигт нийцсэн дижитал сан бүрдүүлэлт, ангилал, кодчлол, программ хангамжийн шийдэл зэрэг чиглэлээр нарийвчилсан судалгааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Монгол үндэсний хувцас нь угсаатны соёл, гоо зүй, урлалын арга ухааны цогц илэрхийлэл бөгөөд түүнийг судлах, хадгалах, хөгжүүлэх нь соёлын дархлаа бэхжүүлэх стратегийн чухал хэсэг юм. Энэхүү судалгаагаар уламжлалт хувцасны хийц, урлалын бүтэц, технологийг морфологи шинжилгээний арга зүйд тулгуурлан системчилж, дижитал мэдээллийн сан бүрдүүлэх боломж, аргачлалын суурийг тавьсан нь онцлох үр дүн боллоо.

Хувцасны бүрдэл хэсгүүд, зохион бүтээлтийн харьцаа, материалын онцлог, технологийн нарийн үйл явцыг бүрэн гүйцэд баримтжуулж, кодчилох нь зөвхөн музейн хадгалалт бус орчин үеийн бүтээлч үйлдвэрлэл, судалгаа, боловсролын салбарт өргөн хэрэглэгдэхүйц мэдлэгийн бааз бүрдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Цаашид уг судалгааг үндэсний болон угсаатны бүлэг тус бүрийн уламжлалт хувцаст өргөжүүлж, системийн судалгааны онол арга зүйг ашиглан дижитал архив, эрдэм шинжилгээний мэдээллийн лавлах сан бүрдүүлэх нь чухал байна. Энэ хүрээнд:

- Угсаатны хувцасны хийц, технологийн судалгааг гүнзгийрүүлэх
- Дижитал кодчлол, технологийн картын нэгдсэн систем хөгжүүлэх
- Орон нутгийн музейн үзмэрүүдийг стандартын дагуу дижиталжуулах
- Орчин үеийн программ хангамж, хиймэл оюун ухаан, 3D технологийг өргөн ашиглах зэргийг хэрэгжүүлснээр үндэсний хувцасны соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, олон улсын түвшинд таниулах боломжийг нэмэгдүүлнэ.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

- Авдай, Ч., Төмөржав, С. 2003. *Монголын нүүдэлчдийн үндэсний уламжлалт технологи*. Улаанбаатар: Бэмби сан.
- Алтанцэцэг, Ч. 2015. “Хүн хувцас орчин системийн хүрээнд дулаан хувцас зохион бүтээх онолын үндэс ба технологи.” Sc.D дисс., ШУА.
- Бадамхатан, С., Цэрэнханд, Г. 1987. *Монгол улсын угсаатны зүй I боть*. Ред. Отгонбаатар Б. Улаанбаатар: МУ-ын ШУА.
- Гантогтох, Г., Дунгаамаа, Б., Эрдэнэцогт, Н. 1998. *Монгол нүүдэлчдийн тайлбар толь I*. Улаанбаатар: Монсудар.

Доржготов, А., Сонгино, Ч. 1998. *Зурагт толь*. Ред. Бадарчи С., Эрдэнэбат Ц. Улаанбаатар.

Дунгаамаа, Б. 2004. “Монгол дээлийн зохион бүтээлтийн судалгаа, боловсруулалт.” Ph.D дисс., Шинжлэх ухаан технологийн их сургууль.

Дунгаамаа, Б. 2022. *Монгол дээлийн зохион бүтээлт*. Улаанбаатар: Жиком пресс.

Ишдорж, Л. 2011. “Монгол үндэсний хувцасны дизайны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох асуудалд.” *ШУТИС-ийн эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл* №2/118: 143-150.

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн. 2004. *Монголчуудын түүх соёлын атлас*. Улаанбаатар.

Нямбуу, Х. 1992. “Монгол хувцасны түүх.” Ph.D дисс., МУИС.

Ольдерогге, Д.А., Иванов.С.В., Потопов.Л.Н., Решетов.А.М., Сабурова.Л.М. 1977. *Одежда народов зарубежной Азии*. Ленинград.

Өлзийгэрэл, Т. 2008. “Халх эхнэр хувцасны зохион бүтээлт.” Магистрын судалгааны ажил., ШУТИС.

Рой Чапман Эндрюс. 1919. *Монгол бүсгүйчүүд, Нийслэл хүрээ*. Улаанбаатар.

Саруулбуян, Ж., Энхтуяа, Л. 2011. *Монголчуудын хувцас*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Цэндсүрэн, Ц. (ред.) *Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис III*. 2014. Улаанбаатар.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн. 2014. *Монголчууд: XVII-XX зууны эхэн*. Чулуун, С. (ред.) Улаанбаатар: Адмон ХХК.

Ядамсүрэн, Ү. 1967. *БНМАУ-ын Ардын хувцас*. Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Bertoluci, C.E., Sanches, R.A. 2020. “Using a morphological chart to develop fashion products from recycled knit waste.” *ModaPalavra eperiódico* 27: 108-137.